

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР №

2021-08-25

		Дансны №	ДҮН
Төлөгчийн нэр:	ЦЕГ-ын "Цагаан Шонхор" ТӨҮҮГ		
Төлөгчийн банк:	Худалдаа хөгжлийн банк	404002409	14,453,800.00

Хүлээн авагчийн нэр :	Агуу их нүрэн ХХК		
Хүлээн авагчийн банк :	Худалдаа хөгжлийн банк	450026557	

Мөнгөний дүн үсгээр :

Арван дөрвөн сая дөрвөн зуун тавин гурван мянга найман зуун төгрөг

Төлбөрийн зориулалт :

Зээлээр авсан материалын үлдэгдэл тооцоо хаав

Барааг хүлээн авсан, ажил үйлчилгээг гүйцэтгүүлсэн:

2021 оны 08 сарын 25 ны өдөр

Захирал:  / Б.Ариунзаяа /

ТАМГА

Ня-бо: / Ц.Цэнгэлмаа /

___ хоногийн ___ хувийн торгууль:
Дүн торгуулийн хамт:
Гүйлгээний утга:
Төлбөрийн зориулалт:
Төлөх хугацаа:
Төлбөрийн зэлж:

Банкны гүйлгээ хийсэн:

ХХБ банк Энхтайврын салбар
N-07
2021.08.25



БАТЛАВ.



ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ
ГЭРЭЭ

2021 оны 01 дүгээр сарын 04 -ны өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас регистрийн 2119668 дугаартай ЦЕГ-ын Цагаан шонхор ТӨҮГГазар /цаашид "Худалдан авагч" гэнэ/-ийг төлөөлж нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа , нөгөө талаас регистрийн 6599877 дугаартай, Агуу их нүрэн ХХК /цаашид "Худалдагч" гэх/-ийг төлөөлж захирал Б.Билгүүн, /хамтад нь "Талууд" гэх/ нар хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэн харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэ гэрээний зорилго нь худалдагч нь худалдан авагчийн өмчлөлд тус гэрээний хавсралтанд заасан тоо ширхэг, чанарын дагуу бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, Худалдан авагч нь барааг тогтоосон хугацаанд хүлээн авч, үнийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 1.3. Худалдагчийн нэхэмжлэх, зарлагын баримт, бүтээгдэхүүн хүлээлцсэн акт зэрэг нь гэрээний хавсралт болох бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл, хугацаа

- 2.1. Гэрээний ажлыг 2021 оны 01-дугаар сарын 04-өөс 2021 оны 12-р сарын 31-ний өдөр дотор нийлүүлнэ.
- 2.2. Гэрээний нийт үнийн дүн 30,000,000 / Гучин сая / төгрөг өөс ихгүй байна.
- 2.3. Гэрээний үнийн дүнд НӨАТ орсон болно.
- 2.4. Худалдан авагч гэрээний нийт төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө:
- 2.5. Гэрээ байгуулснаас хойш шаардлагатай материалыг зээлээр нийлүүлэх ба тухай бүр хүлээж авсан акт нэхэмжлэх зарлагын падаанаар баталгаажуулна. Шаардлагатай бол урьдчилгаа төлбөрийг нэхэмжлэх, зарлагын падааны дагуу шилжүүлэх ба барааг бүрэн хүлээлгэн өгсөн бол ажлын 7 хоногт багтааж гэрээний үнийн дүнгийн 100 хувийг худалдагчийн Худалдаа хөгжлийн банкны Банкны 450026557 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

Гурав. Худалдагчийн эрх, үүрэг

- 3.1. Худалдагч нь гэрээнд заасан үнийг шаардан авах эрхтэй.
- 3.2. Худалдагч нь худалдан авагчийн өмчлөлд гэрээнд заасан хугацаанд биет байдлын доголдолгүй хавсралтанд заасан тоо ширхэг, чанар, үзүүлэлт бүхий бүтээгдэхүүнийг шилжүүлнэ.

3.3. Худалдагч нь бүтээгдэхүүнийг худалдан авагчтай тохиролцсон хуваарийн дагуу бэлтгэж өгнө.

3.4. Худалдсан бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн доголдолтой бол худалдагч нь засварлах, засварлах боломжгүй бол тухайн төрлийн бүтээгдэхүүнээр сольж өгөх үүрэгтэй.

3.5. Худалдагч нь өөрийн нийлүүлсэн бүтээгдэхүүндээ баталгааны хугацаа олгосон байна.

3.6. Баталгаат хугацаа гэдэгт зөвхөн үйлдвэрийн гэмтэл хамаарах бөгөөд хуучралт, бохирдолтой холбоотой гэмтэл, ашиглалтын буруугаас гарсан гэмтэл гэх мэт гэмтэл хамаарахгүй болно.

Дөрөв. Худалдан авагчийн эрх, үүрэг

4.1. Гэрээнд заасан үнийг төлөх үүрэгтэй.

4.2. Бүтээгдэхүүнд үйлдвэрийн доголдол гарсан бол доголдлыг арилгуулах буюу тухайн төрлийн бүтээгдэхүүнээр солиулах эрхтэй.

4.3. Худалдагч нь гэрээнд заасан тоо хэмжээнээс дутуу, үзүүлэлт шаардлага хангахгүй бүтээгдэхүүн шилжүүлвэл худалдан авагч нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.4. Худалдан авагч нь гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүн хүлээж авахдаа иж бүрдлийг шалгаж дагалдах бичиг, баримтын хамт актаар хүлээн авна.

4.5. Худалдан авагч нь бүтээгдэхүүний лац ломбыг хөндөхгүй байх үүрэгтэй.

Тав. Хариуцлага

5.1. Худалдан авагчийн буруугаас бүтээгдэхүүнийг зааврын дагуу ашиглаагүйгээс бүтээгдэхүүнд гарсан гэмтэлийг худалдагч хариуцахгүй.

5.2. Худалдан авагч гэрээний хавсралтад заасны дагуу шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хүлээн авахаас татгалзах болон барааг буцаах эрхгүй.

5.3. Худалдагч бүтээгдэхүүнийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд шилжүүлээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувиар тооцож худалдан авагчид алданги төлнө.

5.4. Худалдан авагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд үүргийн үнийн дүнгийн 0.05 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө.

5.5. Алданги, алданги төлсөн нь талуудыг үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.6. Гэрээний үйлчлэх хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан буруутай тал нөгөө талдаа үүргийн үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний алданги торгууль төлнө.

Зургаа. Гэрээ дуусгавар болох

6.1. Энэ гэрээнд заасан хугацааг хуанлийн хоногоор бодох бөгөөд талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

6.2. Энэхүү гэрээ нь Худалдан авагч тал төлбөрийг төлж барагдуулснаар дуусгавар болно.

6.3. Дараах тохиолдолд Талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.

6.3.1. Талууд харилцан тохиролцсоноор;

6.3.2. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар;

Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд Худалдагчид 1 хувь, Худалдан авагчид 1 хувь хадгалагдсан нь тус тус хуулийн өмнө ижил хүчинтэй.

7.2. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг талууд аль болох харилцан тохиролцоо бие биенээ хүндэтгэх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв маргааныг дээрхи аргаар шийдвэрлэгдэх боломжгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлэнэ.

7.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.

7.4. Гэрээний явцад аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болох бөгөөд саналыг хүлээн авсан тал ажлын 3-аас доошгүй хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тэмдэглэлийг бичгээр үйлдэх бөгөөд тэмдэглэл нь гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

7.5. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа шууд мэдэгдэнэ.

7.6. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НЯГТЛАН БОДОГЧ

Ц.ЦЭНГЭЛМАА

Хаяг: УБ, БЗД 2-р Хороо цагдаа хотхон өөрийн байр

Утас: 88104063, 70151548

tsagaanshonkhonkhor98@yahoo.com

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АГУУ ИХ НҮРЭН ХХК-НЫ ЗАХИРАЛ

НУУЭН ХХК Б.БИЛГҮҮН

Хаяг: УБ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Утас: 88180445

И-мэйл:

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000204309

2020.07.31

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011820159

/ Хувийн хэргийн дугаар /

6599877

/ Регистрийн дугаар /

Агуу их нүрэн

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2020.07.24

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

14300	Оёдлын үйлдвэрлэл
47710	Оёмол бүтээгдэхүүн худалдаа
33140	Оёдлын машины засвар, үйлчилгээ
47910	Онлайн худалдаа
47990	Худалдааны зуучлал

/ Код /

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

4.00

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Чингэлтэй, 12-р хороо, булгийн 10, 503 тоот, Утас1: 99282940, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
газар

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

5250722

118028051